



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 01550

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 164 дүгээр
цэцэрлэгийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,997,510.1 /таван сая есөн зуун ерэн долоон мянга таван зуун арван төгрөг, арван мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэг /Б.Нэргүй/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 6 нэр төрлийн 1,403,842.0 /нэг сая дөрвөн зуун гурван мянга найман зуун дөчин хоёр/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 19 нэр төрлийн 4,593,668.1 /дөрвөн сая таван зуун ерэн гурван мянга зургаан зуун жаран найман төгрөг, арван мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэг /Б.Нэргүй/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050001557

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 12 дугаар
сарын 11 өдрийн 07/80 тоот тушаалын хавсралт

Актлах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХК-н шийдвэр
1	Принтер EPSON/R-230	6	ш	1	380,000.0	380,000.0	380,000.0	-	эвдэрсэн	татах
2	Принтер EPSON XP102	6	ш	1	250,000.0	250,000.0	250,000.0	-	эвдэрсэн	татах
3	Тоос сорогч	12	ш	1	104,285.6	104,285.6	104,285.6	-	эвдэрсэн	татах
4	Монитор	10	ш	2	159,530.0	319,060.0	319,060.0	-	эвдэрсэн	татах
5	Ус буцалгагч	17	ш	1	29,950.0	29,950.0	29,950.0	-	эвдэрсэн	татах
6	Хөгжим	11	ш	1	290,000.0	290,000.0	290,000.0	-	эвдэрсэн	татах
7	Махны машин	46	ш	1	450,000.0	450,000.0	450,000.0	-	эвдэрсэн	татах
8	Принтер	10	ш	1	841,600.0	841,600.0	841,600.0	-	эвдэрсэн	татах
9	Принтер Samsung	6	ш	1	199,900.0	199,900.0	199,900.0	-	эвдэрсэн	татах
Тоног төхөөрөмжийн дүн				10		2,864,795.6	2,864,795.6	-		
10	Хүүхдийн ширээ	27	ш	20	49,500.0	990,000.0	990,000.0	-	эвдэрсэн	татах
11	Хивс	21	ш	2	82,100.0	164,200.0	164,200.0	-	урагдсан	татах
12	Унадаг морь	15	ш	1	70,300.0	70,300.0	70,300.0	-	эвдэрсэн	татах
13	Шатар	15	ш	4	3,515.0	14,060.0	14,060.0	-	эвдэрсэн	татах
14	Дүрс модон ком	15	ш	1	25,308.0	25,308.0	25,308.0	-	эвдэрсэн	татах
15	Самбар	20	ш	1	25,000.0	25,000.0	25,000.0	-	эвдэрсэн	устгах
16	Шар ширээ	28	ш	1	93,606.0	93,606.0	93,606.0	-	эвдэрсэн	устгах

17	Хүүхдийн шкаф	27	ш	13	85,800.0	1,115,400.0	1,115,400.0	-	эвдэрсэн	устгах
18	Сервант	27	ш	1	82,836.0	82,836.0	82,836.0	-	эвдэрсэн	устгах
19	Багш ширээ	19	ш	1	60,000.0	60,000.0	60,000.0	-	эвдэрсэн	татах
20	Сагсны шийд	19	ш	1	87,500.0	87,500.0	87,500.0	-	эвдэрсэн	татах
21	Хөх самбар	20	ш	1	60,000.0	60,000.0	60,000.0	-	хугарсан	устгах
22	Хивсэнцэр /цэнхэр/	11	м	1	17,704.5	17,704.5	17,704.5	-	урагдсан	татах
23	Матрас	24	ш	1	27,000.0	27,000.0	27,000.0	-	урагдсан	устгах
24	Вандан сандал	27	ш	2	22,500.0	45,000.0	45,000.0	-	эвдэрсэн	татах
Тавилга, эд хогшлын дүн				51		2,877,914.5	2,877,914.5	-		
25	Модон сандал	46	ш	14	18,200.0	254,800.0	254,800.0	-	эвдэрсэн	татах
Бусад хөрөнгийн дүн				14		254,800.0	254,800.0	-		
НИЙТ ДҮН				75		5,997,510.1	5,997,510.1	-		
Үүнээс : Худалдах хөрөнгө										
Устгах хөрөнгө						1,403,842.0	1,403,842.0	-		
Татан төвлөрүүлэх хөрөнгө						4,593,668.1	4,593,668.1	-		
Худалдсанаас олох орлого										
НӨАУГ-т төвлөрүүлэх /30%/										